

БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО

Даяаршлын эринд ажиллаж, амьдрах чадвартай, өндөр мэдлэгтэй мэргэжилтэн бэлтгэж, Монгол орныхоо одоо, ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулна.

ЗОХИОМЖ ХЭВЛЭЛИЙН ЗОРИЛГО

Зохиомж дээд сургуулийн эрдэмтэн багш, эрдэм шинжилгээний ажилтанууд болон бакалавр, магистрын зэргээр өдөр болон оройн ангид сурч буй нийт оюутануудыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах орчныг бүрдүүлэхэд оршино.

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм оюутнууд аа, Олон Улсын Бизнес Технологийн Зохиомж Дээд сургууль нь Монгол Улсын дээд боловсролын хурдацтай хөгжин дэвшиж дүй тэргүүний байгууллага юм.

Тус сургуульд элсэн орсон эх орны чадварлаг ирээдүй оюутан залуус та бүхний нэгэн цөийн түүхийг амжилт бүтээл, амьдралаараа дичилцэж гэгээн цүйлэт хөтлөж замыг бид халтгаа дүй болгохоор эрдмийн их өргөөндөө журан цугларлаа. Эх орон, хүн төрөлхтний хүмүүнлэг цүйлэт хувь нэмрээ оруулах, Зохиомж их сургуулийг цогцлоож зорилт бидэнд бий.

Хүн бүрдэд адил эхлэл, ижил заяа, боломж байдаг чамьдралд олон өнгө зэрэгцэн байдаг. Хичээж, өөрийгөө дайчлан суралцаж чадаан нь эрдэм ухааныг олж авч насан туршидаа ухаанарт амьдралаа зориулах мэргэжлээ чадварлаг эзэмшдэг.

Амжилтын шигдэт түлхүүр-хичээл зүтгэл билээ. Эрхэм оюутнууд та нартаа амжилт хүсье.

Б.ЦОГТМБАЯР

БИЗНЕСИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Чанартай сургалт, судалгаа, үйлчилгээ бүхий хөтөлбөрөөр иргэдийн оюуны чадварыг сайжруулж нийгмийн хөгжлийг урагшлуулна.



Валютын ханш

	АНУ доллар	1,974.52
	Евро	2,214.34
	Японы иен	16.55
	Швейцар франк	2,082.72
	Шведийн крон	235.19
	Английн фунт	3,048.76
	ОХУ-ын рубль	32.34
	БНХАУ-н юань	314.92
	БНСУ-ын вон	1.80
	Канадын доллар	1,581.77
	Малайзын ринггит	545.82
	Туркийн лира	791.06



Үйлдвэржилтийг дэмжих төслийн үзэл баримтлалыг баталлаа



Засгийн газар өчигдрийн /II.02/ хуралдаанаараа Үйлдвэржилтийг дэмжих хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцлээ. Ингээд тус хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэн батлаад, хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбатад даалгалаа.

Манай орны экспортын бүтээгдэхүүний 97 орчим хувь нь анхан шатны боловсруулалт хийсэн технологийн агууламж багатай байгаа нь энэ салбарын бүтээгдэхүүн боловсруулах чадавх болон технологийг сайжруулах шаардлагатайг харуулж байна. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай түүхийг

эдийн боловсруулалтын түвшин 10-30 хувиас хэтрэхгүй байгаа ба ихэнх түүхийг эдийг үнэ цэнэ шингээлгүй экспортолдог.

Иймд хөрөнгө оруулалтын үр өгөөж өндөртэй, үнэ цэнэ шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлд үзүүлэх төрийн дэмжлэгийн хэлбэрийг,

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 60-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үндэсний үйлдвэрт технологийн шинэчлэл хийсэн хөрөнгө оруулалтынх нь 50 хувьтай тэнцэх хэмжээний зээлийг төрөөс 10 жилийн хугацаатай хүүгүй, нэг удаа олгох,

Өндөр ашиг бүхий шинэ технологи болон өндөр технологи нэвтрүүлж нутагшуулсан, импортыг орлох болон экспортын үйлдвэрийн эхний бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртлэх хугацаанд судалгаа, хөгжилд зарцуулсан зардлын 75 хувь хүртлэх хэмжээтэй тэнцэх дэмжлэгийг улсын төсвөөс нэг удаа үйлдвэрт буцааж олгохоор тусгажээ.

Хямралын гол шалтгаан нь нүүрс биш юм уу



Монгол Улсын эдийн засгийн хямарсан гол шалтгаан нь нүүрс болж байх шиг. Энд мэргэжилтнүүд янз бүрийн таамаг дэвшүүлж байгаа ч яах аргагүй эцсийн хариулт нь нүүрс болж таарах нь.


Эдийн засгийн хямралын талаар шинжээчид, төрийн түшээд гээд олон хүмүүс янз бүрийн таамаг дэвшүүлж байгаа. Монголчууд бид талхаа их идээд хямарсан гэж хэлэх нь халаг байна. Эрх ямбатнууд хувьдаа завших нь их байснаас, төрийн нүсэр аппаратаас боллоо, алт зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр унасан. Гаднын хөрөнгө оруулалт буурсан, хууль нь буруу байсан. Эрх баригчдаас болсон гээд тоо тоймгүй олон шалтгаан тоочсон. Хямралд энэ бүгд ямар нэгэн хэмжээгээр холбоотой юу гэвэл холбоотой байж таарна.

Гэхдээ хамгийн гол шалтгаан нь нүүрс байсан гэдэг эцсийн хариулт гарч байх шиг. Манайхаас

коксжих нүүрс авдаг гол түншлэгч орон маань хятад. Өөр ямар ч улс орон манайхаас нүүрс зөөвөрлөх боломжгүй. Тиймээс төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компанийг үүсгэн байгуулаад Тавантолгой орд газрыг ашиглалтад оруулаад багагүй хугацаа өнгөрсөн ч сүүлийн жилүүдэд энэ салбарт ахиц гарсангүй. 2012 оноос хойш гурван жилийн хугацаанд нүүрснээс ямар орлого олж байна вэ гэхээр ганцхан л хариулт өгдөг. Бид “Чалко”-д төлөх өрийг барагдуулж байна хэмээн ам тагладаг. Үнэн хэрэгтээ энэ бол Тавантолгойн орд газарт бол тийм ч их өр биш. Төлөөд барагдуулаад өдийд нүүрснээс асар их орлого олсон байх ёстой л доо.

Хамгийн гол нь хятадад нүүрсний хэрэглээ буурсантай л холбоотой байхгүй юу. Үүнийг мэдсээр байж өмнөх Засгийн газрын “Чалко”-д төлөх өрийг барагдуулж байна хэмээдэг. Энэ бол зүгээр л шалтаг. Тэр ч бүү хэл Хятадын нүүрсний хэрэглээ 2020 он хүртэл хэдэн сая тонноор буурах хандлагатайг судалгаагаар гаргасан байна лээ.

Саяханы нэг мэдээлэл сөхвөл зөвхөн “ӨМӨЗО”-оос энэ оны 1-11-р сарыг хүртлэх нүүрс олборлолт нь өнгөрсөн жилийн мөн үеэсээ 109.83 сая тонн багасан, 11.6 хувьд хүрчээ. Энэ нь өнөө жилийн хувьд нүүрс олборлолтыг дээд хэмжээнд багасгасан бөгөөд нүүрс олборлоход хоригтавих ажил үрдүнгээ өгч буйг харуулж байна” хэмээжээ. Тус мэдээллээс харахад л бүх зүйл ойлгомжтой харагдана.



II сарын өдрийн дундаж гүйлгээ 1,5 тэрбум төгрөг байлаа

2 дугаар сард нийт 18 удаагийн арилжааг зохион байгуулж, 66 компанийн 6.9 сая ширхэг хувьцааг 1.2 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 4 удаа зохион байгуулж, 266.4 мянган ширхэг үнэт цаасыг 26.6 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.3 мянган ширхэг үнэт цаасыг 124.9 сая төгрөгөөр арилжиж, нийт 27.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийлээ.

ИДЭВХТЭЙ АРИЛЖАА ЯВУУЛСАН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

ҮЦК-ийн нэр	Үнийн дүн /төгрөгөөр/
TNGR Тэнгэр Капитал ҮЦК	19.9 тэрбум
GLMT Голомт секюритиз ҮЦК	3.4 тэрбум
BDSC БиДиСек ҮЦК	2.3 тэрбум
MONG Монгол секюритиз ҮЦК	541.9 сая
GATR Гацуурт трейд ҮЦК	507.3 сая

Хувьцааны арилжаа:

“Э-Транс ложистик” ХК-ийн 5.0 ширхэг хувьцаа 501.2 сая төгрөгөөр, “22-р бааз” ХК-ийн 1.3 ширхэг хувьцаа 270.3 сая төгрөгөөр, “АПУ” ХК-ийн 17.7 ширхэг хувьцаа 64.2 сая төгрөгөөр, “Материал Импекс” ХК-ийн 2.8 ширхэг хувьцаа 43.4 сая төгрөгөөр, “Баялаг налайх” ХК-ийн 59.8 ширхэг хувьцаа 40.3 сая төгрөгөөр тус тус идэвхтэй арилжигдсан байна.

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

Үнэт цаасны нэр	Үнийн дүн /төгрөгөөр/
EIT “Э-Транс ложистик” ХК	501.2
АНН “22-р бааз” ХК	270.3
APU “АПУ” ХК	64.2
MIE “Материал Импекс”	43.4
BNB “Баялаг налайх”	40.3

Багцын арилжаа:

Тайлант хугацаанд 5 удаа багцын арилжаа явагдаж, нийт 6.5 сая ширхэг хувьцааг 824.3 сая төгрөгөөр арилжсан байна.

Засгийн газрын үнэт цаасны арилжаа:

Энэ сард Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 4 удаа явагдаж, 12,28,52 долоо хоногийн хугацаатай нийт 266.4 мянган ширхэг үнэт цаасыг 26.6 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Мөн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.3 мянган ширхэг үнэт цаасыг 124.9 сая төгрөгөөр арилжсан байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН КОМПАНИУД

Компанийн нэр	Үнийн дүн
TNGR Тэнгэр капитал ҮЦК	19.9 тэрбум
GLMT Голомт секюритиз ҮЦК	3.4 тэрбум
BDSC БиДиСек ҮЦК	1.1 тэрбум
GATR Гацуурт трейд ҮЦК	0.5 тэрбум
TDB ТиДиБи Капитал ҮЦК	0.4 тэрбум

Үнэт цаасны ханш:

Нийт 66 үнэт цаас арилжигдсанаас өмнөх сарын сүүлийн өдрийн хаалтын ханштай харьцуулахад 21 үнэт цаасны ханш осч, 33 үнэт цаасны ханш буурч, 12 үнэт цаасны ханш тогтвортой байлаа.

MSE ALL индекс:

MSE ALL индекс 989.95 нэгж байгаа нь албан ёсоор тооцож эхэлсэнээс 10.05 нэгжээр буюу 1.01 хувиар буурсан байна.

MSE ALL индексийн энэ сарын хамгийн дээд үзүүлэлт нь 1,000.00 нэгж, доод үзүүлэлт нь 984.53 нэгж, дундаж үзүүлэлт 991.62 нэгж байлаа.

Зах зээлийн үнэлгээ:

Зах зээлийн хамгийн өндөр үнэлгээтэй компанид АПУ, Таван толгой, Бэрх уул, Шарын гол, Говь, Багануур, Шивээ овоо, УБ-БҮК, Монгол секьюритис, БиДиСек, Монголын цахилгаан холбоо, Сүү зэрэг компаниуд орж байгаа бөгөөд Монголын хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ 1 их наяд 365.4 тэрбум төгрөг болж өмнөх сараас 12.9 тэрбум төгрөгөөр буюу 0.94 хувиар буурсан байна



Тавантолгойгоо таньж мэдэцгээ

Сүүлийн хэдэн сарын турш Монгол Улсын сайд М.Энхсайхан телевизийн дэлгэц, сонины нүүрнээс салахаа болив. Түүний амнаас унах үг бүрийг бид алдалгүй сонсох гэж хичээнэ. Учир нь тэрээр одоо Тавантолгойн цахилгаан станц төдийгүй бүхэл бүтэн ордыг эргэлтэд оруулах үүрэг хүлээсэн ажлын хэсгийг ахалж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт бууран, Аби даби дүби доллар гэх нь холгүй болсон бидэнд хамгийн ойрын ирээдүйтэй төсөл нь Тавантолгой болж хувирав. Удаан хүлээлгэсэн хэлэлцээ ч эхэлж, талууд өөд өөдөөсөө харан суулаа. Одоогоор ярилцаж байна, зөвшилцөж байна гэх л албан мэдээ дуудана. Хаалттай хаалганы цаана Тавантолгойн ордыг эзэмших консерциумын гишүүд өөр хоорондоо болон манай ажлын хэсэгтэй чухам юу ярьж, ямар тохироо хийж байгааг бид мэдэхгүй.

Хардалт сэрдэлтээ түр азнаад 4 тэрбум ам.доллар гэх их мөнгийг манай авдарт шургуулах Тавантолгойн ордын талаар өгүүлье.

ТАВАН ТОЛГОЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ БУЮУ 1934 ОНООС ӨНӨӨГ ХҮРТЭЛ...

Хачирхалтай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Улаан нуурын хөндий дэх Тавантолгойн ордыг хамгийн анх буюу 1934 онд жирийн малчид илрүүлжээ. Харин улс 1966 онд энэ ордыг албан ёсоор бүртгэж авсан байдаг.

2010 онд манай улс Тавантолгойгоо эргэлтэд оруулах болсноо дэлхий нийтэд зарлав. Ингээд 15 санал иржээ. Үүнээс 6-г нь Засгийн газар судлах шаардлагатай гэж үзэн, богино жагсаалтдаа багтаав. Гэвч асуудал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд очоод гагцхисан юм.

Дөрвөн жилийн дараа буюу 2014 онд Засгийн газраас 6 компанид хамтран ажиллах санал хүргүүлжээ. Өөрөөр хэлбэл өөрсдөө гуйж залсан гэсэн үг. Эдгээрээс 4 нь санал хүргүүлсэнд талархсанаа илэрхийлсэн бол 2 нь хамтарч ажиллахаа илэрхийлэв. Харин засгийн газраас АНУ-ын Reabody Energy компанийг бус 3 улсын хувийн хэвшлээс бүрдсэн консерциумыг (Монгол, БНХАУ, Япон) өнгөрсөн арван хоёрдугаар сард сонгосон юм. **ЭНЭ КОНСЕРЦИУМЫН ДАВУУ ТАЛ ЮУ ВЭ?**

“Гаули” үнэт цаасны компанийн шинжээч Г.Мөнх-Эрдэнэ дээрх асуултад ийн хариулж байна. Монгол Улсыг төлөөлөх Энержи Ресурс компани нүүрсний зах зээлд 5 дахь жилдээ ажиллаж байгаа туршлагатай. Тэд 2009 онд Ухаа худаг дахь ордыг ашиглах болсноор олон улсын зах зээлээс 650 сая ам.доллар босгож чадсан юм. Иймд ТОМ ҮЙЛДВЭРЛЭГЧ-д тооцогдож байна. Тус компани өнгөрсөн жилүүдэд ямар бүтээн байгуулалт өрнүүлснийг дор дэлгэрэнгүй танилцуулна.

БНХАУ-ын төрийн өмчит компани болох Чайна Шөнхуа Энержи компани Таван толгойгоос олборлосон нүүрсийг Хятадын нутгаар тээвэрлэн, гол зах зээл болох Японд хүргэх юм. Иймд энэ компанийг ТОМ ТЭЭВЭРЛЭГЧ гэж дүгнэж байна.

Харин Японы Сумитомо корпораци Таван толгойн нүүрсийг худалдаалах ТОМ БОРЛУУЛАГЧ аж.

Эндээс харахад үнэхээр төгс консерциумыг сонгосон гэлтэй. Тэдний хамтын ажиллагаа үнэхээр сайн зохицол эсэхийг цаг хугацаа л харуулна. Тавантолгойн ордын талаар үргэлжлүүлье.

Энэ орд нийслэлээс 540 км-ын зайтай оршдог.

Социализмын үед хийсэн тооцоо судалгаагаар ордын нүүрсний нөөц 6.4 тэрбум тонн гэж үзсээр ирсэн. Үүний 36 хувь нь коксжих нүүрс бол 64 хувь нь эрчим хүчний нүүрс аж.

Харин Энержи ресурс компани Жоркийн аргачлалаар тооцон, ордын нийт нөөцийг 7.4 тэрбум тонн гэжээ. Үүний 5.4 тэрбум тонн буюу 73 хувь нь коксжих, 2 тэрбум буюу 27 хувь нь эрчим хүчний нүүрс аж.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт ашигладаг технологи ихээхэн хөгжиж, дэвшил гарах тусам нүүрсний ангилалд ч өөрчлөлт гарснаас дээрх тоонууд ихээхэн зөрүүтэй байх болжээ.

Дашрамд хэлэхэд манай дэлхийн нүүрсний нийт нөөц 891 530 тэрбум тонн юм байна. Энэ нөөцийн дийлэнх нь дараах орнуудад байна. АНУ, ОХУ, БНХАУ, Австрали, Энэтхэг, Монгол.

Тэгвэл энэ ордыг шинэ эзэмшигч рүү нь шилжүүлэхээр ажиллаж буй хэлэлцээний талууд ширээний хоёр талд суугаа талууд ЯМАР ГЭРЭЭ байгуулах вэ?

Хөрөнгө оруулалтын гэрээ (260 орчим асуудлыг хөндсөн) Төмөр зам байгуулах концессийн гэрээ (80 орчим асуудлыг хөндсөн)

Төрийн өмчийг төлбөртэй ашиглуулах гэрээ (30 жилийн хугацаатай байна) Ухаа худагаас Гашуун Сухайтын боомт хүртэлх 267 км урттай төмөр замыг тавих ажлыг эхлүүлэхэд 280 сая ам.долларын хөрөнгийг “Чингис” бондоос зарцуулжээ. Иймд Тавантолгойн гол бүтээгдэхүүн болох нүүрсний тээвэрлэлтийг хариуцах субъект болох Чайна Шинхуа Энержид манай тал үнэхээр 280 сая ам.доллар зарцуулсан эсэхээ батлах учиртай. Учир нь бидний ярьж заншсанаар “цавчаа” энэ төсөлд орсон бол бодит өртөг зардал нь 280 саяаа хүрэхгүй байх аюул бий. Уг нь анх энэ төсөлд 280 сая ам.долларын хөрөнгийг Хөгжлийн банкнаас оруулна гэсэн ч яагаад ч юм 280 сая ам.доллар болон өссөн байх юм. Төслийн ТЭЗҮ-д зааснаар нийт 700 сая ам.доллар шаардлагатай. Төлөвлөгөө ёсоор энэ төмөр зам ирэх аравдугаар сард ашиглалтад орно.

Мөн хоёр талаас уулзах замуудын өндөр буюу далан нь бүхэл бүтэн 30 метрээр, хоёр талаас уулзах замуудын уулзвар цэг 10 орчим км-ээр зөржээ. Үүний шалтгааныг Зам тээврийн сайд тайлбарлаагүй л байна.

ТАВАН ТОЛГОЙД ХИЙХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Хөрөнгө оруулагчид урьдчилгаа төлбөрт 150 сая ам.долларыг Монголын талд өгөхөд бэлэн гэдгээ илэрхийлсэн. Энэ нь өгөөш үү эсвэл сайхан сэтгэлийн тусгал уу гэдгийг мэдэхгүй юм.

Хөрөнгө оруулагчид төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт хөрөнгө оруулалтын 30 хувийг өөрийн хөрөнгөөр, үлдсэн 70 хувийг олон улсын банк санхүүгийн байгууллагаас босгоно. 70/30-ийн энэ харьцаа нь олон улсын хөрөнгө оруулалтын зах зээлд тогтсон жишиг аж. Одоогоор дээрх 30 хувийг 3 талаас бүрдсэн консерциум хэрхэн босгох нь буюу хэн хэдэн хувийг гаргах нь бас л тодорхойгүй байна.

Хоёр хоногийн өмнө Сүмитомо корпорацийн ерөнхийлөгч К.Накамура Токиод Ерөнхий сайд Ч.Сайханбилэгтэй уулзсан. Тэрээр консерциум дотроо Сүмитомо гадаад зах зээл дэх маркетинг болон санхүүжилтийг хариуцдаг гэжээ. Тэгэхээр дийлэнх хөрөнгийг Японы тал гаргах бололтой.

ТАВАНТОЛГОЙ ТӨСЛИЙН ГОЛ ӨРСӨЛДӨГЧИД ХЭН БЭ?

ОХУ-д улсад Эльга гэх томоохон төсөл хэрэгжиж эхлэх шатандаа яваа нь Таван толгойн гол өрсөлдөгчид тооцогдох боллоо. Мөн Мозамбикт томоохон нүүрсний орд илрүүлсэн аж. Бид олон улсын зах зээлээс хөрөнгө оруулагч анхлан хайх 2011 онд энэ орд сураггүй байжээ.



БИДНИЙ ХУДАЛДАН АВАГЧ ХЭН БЭ?

Дэлхийн нүүрсний зах зээл гэдэг нь хятадын зах зээл юм. Учир нь тус улс их хэмжээний нүүрс олборлохын сацуу гаднаас ч ихээр нь худалдан авдаг. Чухам ийм шалтгаанаар Тавантолгойн тосолд Бээжин "Чайна Шинхуа Энержи" компаниа сойсон болов уу. Тус улс сүүлийн 100 жилийн турш Австралиас нүүрс худалдан авах болсноор зах зээл нь Австралиас хараат болсон гэхэд болно. Иймд БНХАУ нүүрс худалдан авдаг эх үүсвэрээ олшруулах бодит шаардлагатай нүүрс тулсан тул Тавантолгойд оролцсон гэж ойлгож болно.

Консерциумын 3 дахь оролцогч нь Японы Сумитомо корпораци. Тэд 20 жилийн өмнөөс манай улсад хөрөнгө оруулан, хамтран ажилласан тул Монголчуудын хувьд Сумитомо шинэ танил биш.

СУМИТОМО ЯАГААД ТАВАН ТОЛГОЙД ХАМТРАХ БОЛОВ?

Япон улс нүүрсний томоохон худалдан авагчдын нэг. Гэтэл Японы гангийн үйлдвэрүүд Индонез, Австралиас бас л хамааралтай. Иймд Монголоос хямд, чанартай нүүрс худалдан авах хүсэлтэй байна. Тэд "Чайна Шинхуа Энержи"-д Тавантолгойн нүүрснийг хятадын далайн эрэгт тээвэрлэн авчрах шаардлагыг л тавьж байгаа аж. Хэрэв бид ОХУ-аар дамжуулан, Япон руу нүүрсээ гаргая гэвэл 5000 км туулах бол Хятадаар дайруулахад 2000 км болж, 2.5 дахин бага зам туулна. Тэгэхээр Чайна Шинхуа Энержи Тяньжинээр дамжуулан манай нүүрсийг тээвэрлэх бололтой.

"ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ" КОМПАНИ ЯАГААД АШИГГҮЙ АЖИЛЛАСАН БЭ?

Одоогоор Таван толгой ордод төрийн мэдлийн Эрдэнэс Таван Толгой компани олборлолт явуулж байна. Тэд өнгөрсөн онд хамгийн их нүүрс олборлосон ААН-ээр шалгарав. Мөн Чалкод нийлүүлдэг нүүрсний үнийг тонн тутамд нь 70-аас 91 ам.доллар болгон өсгөж чадсан.

Гэвч төр муу менежер гэдэг. Үүнийг батлах мэт "Эрдэнэс таван толгой" компани өнгөрсөн хугацаанд буяны үйл хийсээр ирвэ. Тус компаниар дамжуулан БНХАУ-ын "Чалко" компаниас 350 сая долларын зээл авснаа эрх баригчид эх орны хишиг болгоод тараачихсан. Бид ч алгаа тосон авсан. Одоо "Эрдэнэс тавантолгой" компанийн нийт өр 850 тэрбум төгрөг. Үүнд Чалкогийн өр багтсан аж. Дэлхийн зах зээлд нүүрсний үнэ огцом буурсан нь компанийн ажиллагаанд нолоолсон биз. Гэхдээ "Эрдэнэс таван толгойн" ТУЗ-ийн захирлын цалин сард 6 сая төгрөг, ТУЗ-ийн гишүүний цалин 1.5 сая төгрөг байв. Энэ мэтээр шагнал урамшууллыг замбараагүй олгожээ.

Тус компанийн ТУЗ 8 гишүүнтэй бөгөөд дараах албан тушаалтнууд томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга-Ч.Сайнбилэг, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын дэд дарга (Өмнө нь энэ албыг өнөөх алдарт хүрэн хүү Г.Дэнзэн хашиж байсныг сануулъя)

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга - Д.Чулуунхүү

ТУЗ-н гишүүн - Б.Шинэбаатар, Эдийн Засгийн Хөгжлийн яам -Төрийн нарийн бичгийн дарга

ТУЗ-н гишүүн-Б.Батзаяа, Зам Тээврийн яам -Төрийн нарийн бичгийн дарга

ТУЗ-н гишүүн-Д.Батболд, Уул Уурхайн яам-Уул уурхайн газрын захирал

ТУЗ-н гишүүн - Ж.Батболд, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн яам -Төрийн нарийн бичгийн дарга

ТУЗ-н гишүүн - Н.Энхтуяа, ЗГХЭГ Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Хараат бус гишүүн - Д.Түмэнжаргал

Хараат бус гишүүн - Б.Бат-Эрдэнэ, Хасу-Эрчим"ХХК-ийн захирал

Хараат бус гишүүн - Ч.Батсайхан

Мөн тус компанид 1.8 тэрбум төгрөгийн буюу маш өндөр үнэтэй дугуй шахсан гэх дуулиан тарсан ч энэ хэрэг таг чиг боллоо.

Гэтэл Тавантолгойтой хаяа дэрлэн оршдог Ухаа худагт ямар бүтээн байгуулалт өрнөв?

2009 оноос хойшхи харьцангуй богино хугацаанд Ухаа Худаг уурхай нь

Нүүрс баяжуулах үйлдвэр (жилд 18 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай),

18 мегаваттын цахилгаан станц,

Усан хангамжийн систем,

"Цэций" орон сууцны хороололд 560 орх амьдардаг. Мөн эмийн сан, 8 нэрийн хүнсний дэлгүүр, хүүхэд өнжүүлэх тов, хөгжмийн сургалтын тов, бариа засал, шүд, нүдний эмнэлэг, кино театр, хүүхдийн тоглоомын тов болон яаралтай тусламжийн тов, цэцэрлэг ажиллаж байна.

Хүнд машин механизмд засвар үйлчилгээ үзүүлэх орчин үеийн засварын тов,

Ажиллагсдын нэгдсэн офис,

Уурхайн оператор бэлтгэх симулятор сургалтын тов гээд техникийн болон нийгмийн дэд бүтцүүдтэй, аж үйлдвэрийн томоохон цогцолбор болон өргөжсөн.

2013 оны эцсийн байдлаар Энержи Ресурс компанийн үндсэн ажиллагсдын тоо 2,200-д хүрсэн. Ухаа Худаг цогцолборын хүрээнд 4,000 орчим хүн шууд ажлын байраар хангагдаж байна. Ухаа Худаг уурхайн нүүрс олборлолтын хэмжээ 2013 онд 9.7 сая тоннд хүрсэн.

Тавантолгойн хөрөнгө оруулагчдын багт "Энержи ресурс" гэх энэ монгол компани багтсанд бид бага ч болов сэтгэл өгөж байгаа юм. Гэтэл тус компани 1.3 тэрбум ам.долларын өртэй. Энэ бол бага тоо биш. Тэгэхээр "Энержи ресурс" эгзэгтэй үедээ байна. Өөрөөр хэлбэл Тавантолгойн тосол амжилттай хэрэгжвэл энэ компанийн ирээдүй гэрэлтэх ч төсөл амжилт олохгүй бол "Энержи ресурс" дампуурах эрсдэлтэй. Иймд сүүлийн жилүүдэд ихээхэн зардлаа танасан тус компани энэ удаад их хэмжээний ашиг олох ёстой болж байна.

ТАВАН ТОЛГОЙГООС БИД ЮУ ХҮРТЭХ ВЭ?

Энэ төсөл хэрэгжсэнээр урт болон дунд хугацаанд дараах эерэг оорчлолт гарна гэж таамаглаж байгаа юм.

Ажлын байр нэмэгдэнэ

Дагалдах бизнесүүд өргөжнө. Ханган нийлүүлэгчид, үйлчилгээ үзүүлэгчдийн бизнест сайнаар нолоолно.

Экспортын орлого өснө. Хөрөнгө оруулагчид Тавантолгойгоос жилд 30 сая тонн нүүрс олборлохоор тооцоолсон. Тонн тутмыг нь 80 ам.доллараар худалдлаа гэхэд экспортын орлого нь жилд 2.4 тэрбум ам.доллар байх юм.

Монгол Улсын валютын нөөц өснө.

Нүүрсний тээврийн зардал буурна. Одоогоор бид авто замаар нүүрсээ тээвэрлэдэг учир тонн тутмынх нь тээврийн зардал 17 ам.доллар. Харин томор замаар тээвэрлэснээр 3 ам.доллар болж буурах боломжтой аж.

Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хэмжээ өснө. "Энержи ресурс" компанийн нүүрс угаах үйлдвэр жилд 18 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай. Гэвч тэд тэр бүр хүчин чадалаа бүрэн ашиглаж чадалгүй, жилд 5 сая тонн нүүрс угаадаг байна. Иймд Ухаа худаг дахь нүүрс угаах үйлдвэрийг бүрэн хүчин чадалаар нь ашигласнаар манай улсын нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний хэмжээ эрс өсөх юм.

Үйлдвэрлэлийн хэмжээ өсөх тусам өртөг буурдаг жишиг бий.

Тавантолгойтой холбоотой ХАРИУЛТГҮЙ ҮЛДСЭН АСУУЛТУУД Оюултолгойгоос ялгаатай нь Тавантолгой ордод Монголын төр хувь эзэмшихгүй. Эзэмшье гэвч бидэнд одоогоор ийм чадал алга. Иймд бид орд эзэмшигчээс ашгийн татвар л авна. Нөөц ашигласны төлбөр болох роялтийг хуульд борлуулалтын 5-10 хувь байна гэж заажээ.

Тэгэхээр хэлэлцээний багийнханд 5 болон 10 хувь гэсэн хоёр сонголт үлдэж байгаа юм. Манай тал буюу М.Энхсайхан даргаар ахлуулсан ажлын хэсэг 10 хувийн төлөө л зүтгэнэ гэж найдаж байна.

Харин хөрөнгө оруулагчид зардлаа бага барихын тулд мэдээж хэрэг 5 хувиар төлнө гэх биз.

Иргэдэд хамгийн их хамааралтай ч өнөөг хүртэл хариултгүй үлдэж байгаа бас нэг асуудал бол 1072 ширхэг хувьцааг хүчинтэй хэмээн тооцох эсэх юм.

Төгсгөлд нь хэлэхэд Монгол Улс Тавантолгойн төслийг хэрэгжүүлэхдээ санхүүгийн эрсдэл үүрэхгүй гэдэг. Энэ нь хөрөнгө оруулагчид ашигтай ажиллахгүй бол бид ч бас ашиг олохгүй гэсэн үг юм. Харин ажлын хэсгийнхэн хөрөнгө оруулалтын бүхий л хугацаанд Монгол улс татварын орлого болон хөрөнгө оруулалтын өгөөжийг хүртэнэ гэж үзэж байна.